



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗАР**

Наадамчдын зам 1200, Арцатын ам, 23 дугаар хороо,
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17100
Утас: (976-11) 32 04 61, Факс: (976-11) 32 18 08
Цахим хуудас: www.uda.ub.gov.mn

2024.01.18 № 01/02/140
танай _____-ны № _____-т

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ЯАМАНД, МОНГОЛЫН
АРХИТЕКТОРУУДЫН ЭВЛЭЛ ТББ-Д,
БАРИЛГЫН ЗУРАГ ТӨСӨЛ
ЗОХИОГЧДЫН ХОЛБОО ТББ-Д,
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ
ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАРТ,
БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВД

**Санал ирүүлж хамтран ажиллах
тухай**

Хот байгуулалтын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан Аймаг, нийслэл, хотын Ерөнхий архитекторын эрх, үүргийн хүрээнд нийслэлийн хэмжээнд Хот төлөвлөлтийн асуудал хэлэлцэх мэргэжлийн зөвлөлийн хурлыг тогтмол нээлттэй зохион байгуулж архитекторууд өөрийн зохиосон зураг төслийг танилцуулан мэргэжлийн байгууллагатайгаа харилцан зөвшилцөх боломжийг бүрдүүлсэн.

2023 онд тус Мэргэжлийн зөвлөлийн 48 удаагийн хурлаар нийт 1477 асуудал хэлэлцүүлсэн. Үүнээс Загвар зураг батлуулах 568 асуудлаас 374 дэмжигдэж батлагдсан боловч давхардсан тоогоор 1000 гаруй удаа хууль, норм дүрэм, стандартын шаардлагад нийцүүлэхээр хянан буцаагдаж байна.

Нийслэлийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дүгээр захирамжаар “Тохижилт-Бүтээн байгуулалтын жил” болгон зарласантай холбогдуулан төлөвлөж буй барилга орчмын гудамж замын тавигдах шаардлага, стандарттай нийцүүлэн барилгын гадна фасадыг цаг агаарын эрс тэс уур амьсгалтай онцлогт тохируулж барилгын чанар стандартад нийцсэн ачаалал даахуйц материалаар хийх, нэгж хорооллын зонхилох өнгөтэй уялдуулах, хаяг рекламьг сайжруулах, сэргээгдэх эрчим хүчний байгууламж төлөвлөх, зөвлөх болон мэргэшсэн архитекторуудын дардсыг идэвхитэй ашиглуулах, архивын баримт бичгийн стандартын дагуу форматыг шинэчлэх зэрэг ажлуудыг зохион байгуулах шаардлагатай байгаа тул Загвар зургийн үлгэрчилсэн загварын боловсруулалтад санал өгч хамтран ажиллахыг хүсье.

Хавсралтаар Архитектур төлөвлөлтийн даалгавар, Загвар зургийн үлгэрчилсэн загварыг хүргүүлэв.

1 дүгээр хавсралт: Загвар зургийн үлгэрчилсэн загвар, 27 хуудастай.

2 дугаар хавсралт: Архитектур төлөвлөлтийн даалгаврын үлгэрчилсэн загвар, 4 хуудастай.

ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.ХАН-УУЛ



C:\Users\mungunzul\Desktop\2024_tomblank.docx

1750020058